



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
БАТШИРЭЭТ СУМЫН “БАТШИРЭЭТ” СУМ  
ДУНДЫН ОЙН АНГИЙН ДАРГЫН ТУШААЛ**

2026 оны 01 сарын 02 өдөр

Дугаар 5103.

Батширээт сум

Эрхийн бичиг, гарал үүслийн гэрчилгээ  
олгох эрх шилжүүлэх тухай

Монгол улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Монгол улсын Ойн тухай хуулийн 34.1 дэх заалт, 34.4 дэх заалт, гарал үүслийн гэрчилгээ олгох, хяналт тавих журмын 2.1.5 дах заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ойгоос мод бэлтгэх эрхийн бичиг, гарал үүслийн гэрчилгээ олгох эрхийг ерөнхий инженер (Б. Батчимэг), ойн техникч (Б. Дуламжав) -д даалгасугай.
2. Ойгоос мод бэлтгэх эрхийн бичиг, гарал үүслийн гэрчилгээг холбогдох хууль тогтоомж, аймаг, сумын ойгоос мод бэлтгэх дээд хязгаарт багтаан олгож ажиллахыг ерөнхий инженер (Б. Батчимэг), ойн техникч (Б. Дуламжав) -д үүрэг болгосугай.

ДАРГА *Б. Батчимэг* ГАНТУЯА

